



**ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД
МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН ТУХАЙ СҮҮЛИЙН 5
ЖИЛИЙН СУДАЛГАА**

СУДЛААЧ:

Т.ОДГЭРЭЛ (МИЛА-ны мэргэжилтэн)

ЗАХИАЛАГЧ:

ЭМЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газар

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон тухай сүүлийн 5 жилийн судалгаа

Оршил:

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйл, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-аар зохицуулагддаг.

Монгол Улсад 2003 оноос хойш гадаадын 53 орноос 2682 эмч, 274 сувилагч нийт 2956 гадаадын эмнэлгийн мэргэжилтэн ирж ажилласан байна. Эдгээр эмнэлгийн мэргэжилтнүүд нь 29 үндсэн мэргэшил, 74 төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.


Зорилго:

Сүүлийн 5 жилд Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон талаарх судалгааг нэгтгэж, бодлого боловсруулагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах.


Үр дүн:

Монгол Улсад ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэдээллийг сүүлийн 5 жилийн байдлаар нэгтгэн гаргалаа. 2015 оны 01 дүгээр сараас 2019 оны 11 дүгээр сарын хооронд Эрүүл мэндийн сайдын нийт 193 тушаалаар давхардсан тоогоор 1374 гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон байна.

1. Сүүлийн 5 жилийн хугацаанд батлагдсан Эрүүл мэндийн сайдын 193 тушаалыг он тус бүрээр авч үзвэл:



2. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан 1374 гадаадын эмнэлгийн мэргэжилтний 1222 нь эмч, 152 нь сувилагч байна. Эдгээрийг он тус бүрээр авч үзвэл:



Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон тухай сүүлийн 5 жилийн судалгаа


3. Нийт 32 орны мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 хоногоос 1 жилийн хугацаатайгаар олгосон байна. Эдгээр орнуудыг авч үзвэл:

№	Дэлхийн улс орнууд	Мэргэжилтний тоо	№	Дэлхийн улс орнууд	Мэргэжилтний тоо	№	Дэлхийн улс орнууд	Мэргэжилтний тоо
1	Австралийн Холбооны Улс	21	12	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	315	23	Малайз Улс	1
2	Америкийн Нэгдсэн Улс	118	13	Бүгд Найрамдах Эквадор Улс	5	24	Мехикийн Нэгдсэн Улс	1
3	Бүгд Найрамдах Австри Улс	7	14	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	78	25	Оросын Холбооны Улс	17
4	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс	34	15	Гүрж Улс	2	26	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс	27
5	Бүгд Найрамдах Итали Улс	9	16	Данийн Вант Улс	7	27	Сингапур Улс	8
6	Бүгд Найрамдах Кипр Улс	1	17	Израиль Улс	7	28	Тайландын Вант Улс	2
7	Бүгд Найрамдах Колумб Улс	3	18	Испанийн Вант Улс	5	29	Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс	1
8	Бүгд Найрамдах Куба Улс	21	19	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	7	30	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	72
9	Бүгд Найрамдах Солонгос Улс	385	20	Канад Улс	46	31	Холбооны Бүгд Найрамдах Мьянмар Улс	1
10	Бүгд Найрамдах Филиппин Улс	1	21	Люксембургийн Их Гүнт Улс	4	32	Япон Улс	138


Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон тухай сүүлийн 5 жилийн судалгаа

11	Бүгд Найрамдах Франц Улс	29	22	Бүгд Найрамдах Индонез Улс	1			
----	--------------------------------	----	----	-------------------------------------	---	--	--	--

4. Бүс нутгаар нь авч үзвэл:



5. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаагаар нь авч үзвэл:



6. Гадаадын эмнэлгийн мэргэжилтнүүдэд нийт 73 төрөлжсөн мэргэшлийн дагуу эмчлэх, сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон байна. Эдгээрийг үндсэн мэргэшлийн дагуу авч үзвэл:

д/д	Үндсэн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрөл олгосон тоо
1	Нүүр ам судлал	177
2	Анатомийн эмгэг судлал	1
3	Арьс судлал	10
4	Гэмтэл согог судлал	55
5	Дотрын анагаах судлал	57


**Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгосон тухай сүүлийн 5 жилийн судалгаа**

6	Дүрс оношилгоо судлал	14
7	Ерөнхий мэргэшил судлал	1
8	Мэдрэл судлал	3
9	Мэдээгүйжүүлэг судлал	71
10	Мэс засал судлал	322
11	Нүд судлал	108
12	Өрхийн анагаах судлал	10
13	Сүрьеэ судлал	1
14	Сэтгэц судлал	4
15	Хавдар судлал	5
16	Халдварт өвчин судлал	0
17	Хүүхэд судлал	80
18	Чих, хамар, хоолой судлал	32
19	Эмнэл зүйн эмгэг судлал	1
20	Эрчимт эмчилгээ судлал	0
21	Эх барих, эмэгтэйчүүд, судлал	39
22	Яаралтай тусламж судлал	41
23	Сэргээн засал судлал	10
24	Уламжлалт анагаах ухаан судлал	179
25	Сувилахуй судлал	150
26	Эрэгтэйчүүд судлал	2
27	Урьдчилан сэргийлэх анагаах ухаан	1

7. Нийт эмч мэргэжилтнүүдээс нийслэлд 1091, орон нутагт 283 мэргэжилтэн ирж ажилласан байна.

8. Улсын эмнэлэгт 984 мэргэжилтэн ирж ажилласан бол хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад 390 мэргэжилтэн ажилласан байна. Эдгээрээс улсын эмнэлэгт ирж ажилласан шатлалаар нь авч үзвэл:

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон тухай сүүлийн 5 жилийн судалгаа



Гадаадын эмнэлгийн мэргэжилтний үзүүлсэн тусламж үйлчилгээ:

2018 онд Улсын эмнэлэгт ирж ажилласан гадаадын эмнэлгийн мэргэжилтнүүд нь дараах чиглэлийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүйгээр үзүүлсэн байна. /Зөвхөн тайлан ирүүлсэн байгууллагын тоон мэдээгээр/.

1. Нүүр ам судлал – Нийт 2530 хүүхэд, 739 насанд хүрэгчдэд амны хөндийн үзлэг хийж, зөвлөгөө өгсөн байна. Үзлэгт хамрагдсан хүүхдүүдэд цоорлын эсрэг фторт түрхлэг, гель түрхэж, үрэвсэл, цоорол, шүдний чулуу оношоор эмчилгээ хийсэн. Эрүү нүүрний гажигтай 25 хүүхдэд үзлэг хийснээс 16 хүүхдэд уруул тагнайн сэтэрхий, шаамий засах мэс засал хийсэн.
2. Арьс судлал – Арьс, харшлын эмгэгтэй 7 хүүхэд, 23 насанд хүрэгчид нийт 30 хүнд үзлэг, эмчилгээ хийсэн.
3. Гэмтэл согог судлал – SMOPP төслийн хүрээнд түнхний мултрал, ясны төрөлхийн гаж хөгжилтэй нийт 30 хүүхдэд үзлэг хийгдэж, 6 хүүхдэд битүү аргаар түнхний мултрал оруулах ажилбар хийгдсэн.
4. Дотрын анагаах судлал – Зүрх судасны эмгэгтэй, төрөлхийн гажигтай 278 хүүхэд, 180 насанд хүрэгчид үзлэгт хамрагдсан. Үүнээс 40 хүүхдэд артерийн битүүрээгүй цорго хаах, зүрхний төрөлхийн цоорхойг нөхөх, уушгины артерийн нарийслийг тэлэх зэрэг мэс засал, насанд хүрэгчид 10 хүнд хавхлагын, аортын хавхлага болон өгсөх хэсгийн аневризм, төрөлхийн гажгийн мэс засал хийсэн байна.
5. Мэдрэл судлал – Нийт 80 хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгснөөс 13 хүнд хүзүү, цээж болон хэвлийн хөндийрүү түрж, олон эрхтэн систем хамарч ургасан нугасны хавдар авах, хүзүүний нугалмай нөхөн сэргээх, урд ба арын бэхэлгээ хийх, тархины суурь хэсгийн хавдар авах, тархины ховдол-зүрхний тосгуурыг холбосон шунт тавих мэс засал эмчилгээнүүд хийгдсэн байна.
6. Мэс засал судлал – Бөөрний мэс заслын эмч нар бөөрний усжилт, шээсний сүвний нарийсал, дутуу хөгжилтэй нийт 57 хүүхдэд үзлэг хийснээс 28 хүүхдэд уретропластик, шээсний цорго хаах, бөөрний нөхөн сэргээх, бөөрний сөөргөө урсгал арилгах зэрэг мэс засал эмчилгээ хийсэн, мөн 57 насанд хүрэгчдэд үзлэг хийж, бөөрний хавдрын үеийн эрхтэн хадгалах мэс засал, бөөр авах, нарийн гэдсээр давсаг орлуулах, шээдэг сүвний нөхөн сэргээх, бөөрний усжилтын нөхөн сэргээх мэс засал болон бөөрний мэс заслын лазер эмчилгээ зэргийг хийсэн

**Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгосон тухай сүүлийн 5 жилийн судалгаа**

байна. Ивэрхийн мэс заслын багийн эмч нар 81 хүнд үзлэг хийж, цавины, хэвлийн өмнөд ханын, хүйсний, өрцний ивэрхий нөхөх мэс засал эмчилгээг хийсэн байна. Мэс заслын эмгэгтэй 25 хүүхдэд үзлэг хийснээс 13 хүүхдэд хошного гаргах, дэлүү авах мэс засал эмчилгээ хийсэн.

7. Нүд судлал – Нийт 120 хүүхэд, 2115 насанд хүрэгчдэд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн байна. Үүнээс нүдний болор цайх эмгэгтэй 13, хяларын 10, нүдний нөхөн сэргээх мэс засал 10 нийт 33 хүүхдэд нүдний мэс засал эмчилгээ хийсэн байна. Насанд хүрэгчид нийт 241 хүнд болорын болон торлогийн мэс засал, нүдний нөхөн сэргээх, нүдний хавдрын мэс засал эмчилгээг хийсэн байна.
8. Хавдар судлал – Нийт 203 хүн үзлэгт хамрагдсанаас толгой хүзүүний хавдартай 14, цээжний хавдартай 18 хүнд хавдар тайрах болон нөхөн сэргээх мэс засал, элэгний хавдартай 3 хүнд элэг тайрах мэс засал, 8 хүнд амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээг хийсэн байна.
9. Уламжлалт анагаах ухаан – Нийт 4615 хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн байна.

Нийт 8 байгууллага дээр 5-17 хүний бүрэлдэхүүнтэй гадаадын эмнэлгийн мэргэжилтнүүд багаараа ирж урьдчилан сэргийлэх үзлэг хийж, тусламж үйлчилгээ үзүүлсэн бөгөөд нийт үзлэгт 11938 хүн хамрагдсан байна. /Нийт үзлэгийн тоог багцалж өгсөн.

2018 онд Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага дээр ирж ажилласан гадаадын эмнэлгийн мэргэжилтнүүд дараах чиглэлээр төлбөртэй тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. /Зөвхөн тайлан ирүүлсэн байгууллагын тоон мэдээгээр/. Үүнд:

1. Нүүр ам судлал – Нийт 1233 хүнд амны хөндийн үзлэг, зөвлөгөө өгч, эмчилгээнд хамруулсан байна.
2. Дотрын анагаах судлал – Зүрх судасны эмгэг болон дотрын өвчний чиглэлээр 1462 хүн, ревматологийн чиглэлээр 1129 хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн байна.
3. Мэдрэл судлал – Нуруу нугасны эмгэгтэй 221 хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн. Үүнээс Ахар сүүлийн эпидурал зайгаар тусгай гуурс хийж тодосгогч бодис хийж мэдрэлийн гарах ёзоорын зайг шалгаж хэрэв битүүрсэн байвал сэтгэх, наалдац салгах, үрэвсэл дарах эмчилгээг 16, Мэдрэлийн ёзоорын үрэвсэл болон фасет үеийн үрэвсэл захын мэдрэлийн үйл ажиллагааг сайжруулах эмчилгээг 54 хүнд хийсэн.
4. Мэс засал судлал – Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын эмгэгтэй 545 хүнд үзлэг хийж, геморрой болон парапроктитын мэс засал эмчилгээг 141 хүнд хийсэн.
5. Нүд судлал – Нийт 840 хүн үзлэгт хамрагдсанаас торлогийн мэс засал 81, болорын мэс засал 236, лазик 41, нүдний даралтны мэс засал 26 хүнд хийсэн байна. /Үүнээс 43 мэс засал эмчилгээг үнэ төлбөргүй хийсэн байна/.
6. Дүрс оношилгоо судлал – Нийт 12612 хүнийг ЭХО болон рентген, компьютерт томографийн шинжилгээнд хамруулсан байна.
7. Эх барих, эмэгтэйчүүд судлал – Нийт 396 хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгснөөс өндгөн эс гаргаж авах ажилбар 305, эмбрион суулгах 173, эмбрион хөлдөөх 140, умайн хөндийд эм цацах ажилбар 65 хүнд хийсэн байна.
8. Эрэгтэйчүүд судлал – Нийт 416 хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн байна.

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон тухай сүүлийн 5 жилийн судалгаа

9. Уламжлалт анагаах ухаан судлал – Нийт 5059 хүнд судас барьж оношилгоо хийсэн ба 1105 хүнд зүү, хануур, төөнүүр, тан, самнуур зэрэг эмчилгээг хийсэн байна.

Дүгнэлт:

1. 2015 оны 01 дүгээр сараас 2019 оны 11 дүгээр сарын хооронд “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай” Эрүүл мэндийн сайдын нийт 193 тушаал батлагдаж, давхардсан тоогоор 1222 эмч, 152 сувилагч нийт 1374 мэргэжилтэнд эмчлэх, сувилах зөвшөөрөл олгосон байна.

2. Дэлхийн Улс орнуудаас ирж ажилласан мэргэжилтний тоог харьцуулж үзэхэд дийлэнх нь БНСУ /385 буюу 28%/, БНХАУ /315 буюу 22,9%/, Япон Улс/138 буюу 10%/-аас, бүс нутгаар нь авч үзвэл дийлэнх нь Ази /965 буюу 70,2%/, Хойд Америк /186 буюу 13,5%/, Европ /159 буюу 11,6%/-ийн орнууд эзэлж байна.

3. Монгол Улсад богино буюу 1 сар хүртэл хугацаагаар 973, урт буюу 1 сараас 1 жил хүртэл хугацаагаар 401 мэргэжилтэн ирж ажилласан байна. /Давхардсан тоогоор/

4. Ирж ажилласан гадаадын эмнэлгийн мэргэжилтнүүдийн дийлэнх нь мэс засал судлал /322 буюу 23,4%/, уламжлалт анагаах ухаан судлал /179 буюу 13%/, нүүр ам судлал /177 буюу 12,9%/-ын чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

5. Нийт гадаадын эмнэлгийн мэргэжилтнүүдийн 79,4% нь нийслэлд, 20,6% нь орон нутагт ажилласан байна. Улсын эмнэлэгт 71,6% нь /1-р шатлалд 1,6%, 2-р шатлалд 35,1%, 3-р шатлалд 58,3%/, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад 28,4 % нь ажилласан байна.

6. 2018 онд Улсын эмнэлэг дээр нийт 3072 хүүхэд, 20031 насанд хүрэгчид үнэ төлбөргүй үзлэгт хамрагдаж, эдгээрээс 136 хүүхэд, 409 насанд хүрэгчид төрөлжсөн нарийн мэргэжлийн мэс засал эмчилгээнд үнэ төлбөргүй хамрагдсан бөгөөд Хувийн хэвшлийн эмнэлэг дээр 23913 хүн үзлэг, эмчилгээнд хамрагдсан байна. /Зөвхөн тайлан ирүүлсэн байгууллагын тоон мэдээгээр.